

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны .. дүгээр
сарын.....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга,
журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, 9.1.13 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.12 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г нэгдүгээр, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ыг хоёрдугаар, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай.

2.1. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д:

1/ Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар шуурхай хангаж, чиглэл бүхий албан даалгавар хүргүүлэх;

2/ Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хянахад ашиглаж байгаа удирдлага, мэдээллийн систем, програмыг шинээр хөгжүүлэх, нэвтрүүлэх;

3/ Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь болон түүнд үндэслэсэн эрүүл мэндийн байгууллагуудын төсөв, тоо хэмжээнд хяналт тавих, төсвөөс давсан зардал төлөвлөхгүй байх, сангийн тэнцлийг хангаж, өр төлбөргүй ажиллахад хяналт тавих;

2.2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга (С.Энхболд)-д:

1/ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулах гэрээний шалгуур үзүүлэлт, тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд тавигдах чанар, төлбөрийн хяналтын шалгуурыг шинэчлэгдсэн багц, журмуудтай уялдуулан шинэчилж нэхэмжлэлийн хяналтыг хийх;

2/ Эрүүл мэндийн даатгалын цахим програм хангамжид холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулж, нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч, санхүүжүүлэх;

3/ Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад болон иргэн, даатгуулагчдад шинэчлэн батлагдсан тогтоол, журмын талаар сургалт, мэдээллийг цогцоор нь хүргэх ажлыг зохион байгуулах;

4/ Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт нийцүүлэн эрүүл мэндийн байгууллагуудтай төсөв, тоо хэмжээ, тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанарын шалгуур үзүүлэлт бүхий иж бүрэн гэрээг 2025 оны 1 дүгээр сард багтаан байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж сангийн тэнцлийг хангаж, өр төлбөргүй ажиллах;

5/ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулаагүй, гэрээг зөвшөөрөөгүй, хэлэлцээрт орохоос татгалзсан, тоо хэмжээг хэтрүүлэн нэхэмжилсэн зэргээр өр төлбөр үүсгэхэд нөлөөлсөн бол холбогдох эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлийг түдгэлзүүлэх, шаардлагатай бол гэрээг цуцлах, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хэрэгжилтийг танилцуулах;

2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт:

1/ Эрүүл мэндийн байгууллагын цахим програмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийх, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээ тус бүрийг хурууны хээ болон бусад орчин үеийн дэвшилтэт аргыг ашиглан баталгаажуулж бодит цагийн горимоор нэхэмжлэх;

2/ Иргэн, даатгуулагчид эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ, тогтоол, журмын талаар үнэн зөв мэдээллээр тасралтгүй хангаж, чанартай тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх;

3/ Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь, түүнд үндэслэсэн гэрээнд заасан төсөв, тоо хэмжээг баримталж ажиллах, орлогын дүнтэй уялдсан зардлыг төлөвлөж зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах;

4/ Лавлагаа шатлалын ачаалал бууруулах, сангийн үр ашгийг дээшлүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, түүний үр дүнг сайжруулах, шаардлагагүй оношилгоо, шинжилгээ, эмчилгээ үзүүлэхээс татгалзаж ажиллах;

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдэд, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т, тогтоолыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажиллахыг ажлын албаны дарга /Ц.Сарантуяа/-д даалгасугай.

ДАРГА

Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны ... дүгээр сарын.... -ны өдрийн . . . дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ
ХАРИУЦАХ ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Хүснэгт 1. Нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ

№	Хүн амын эрүүл мэндийн эрсдэлийн бүлэг		Хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент	Хүн амын эрсдэлийн бүлгээр тооцсон, нэг иргэнд ногдох төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
	Насны бүлэг	Оршин суугаа газар		
1	5 хүртэлх нас	Гэр хороолол	3.0	106,632
2		Орон сууц	2.6	92,414
3	6-15 нас	Гэр хороолол	1.3	46,208
4		Орон сууц	1.2	42,652
5	16-49 насны эмэгтэйчүүд	Гэр хороолол	1.4	49,762
6		Орон сууц	1.4	49,762
7	60 наснаас дээш	Гэр хороолол	1.9	67,534
8		Орон сууц	1.7	60,424
9	Бусад*	Гэр хороолол	1.1	39,098
10		Орон сууц	1.0	35,544
Дундаж төлбөрийн хэмжээ				59,003

* - 16-49 насны эрэгтэйчүүд, 50-59 насны эрэгтэй, эмэгтэйчүүд

Хүснэгт 2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ

№	Код	Тусламж, үйлчилгээний багц	Тусламж, үйлчилгээний нэр	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
1	10000001	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	Архаг үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ	80,000
2	10000002	Өдрийн эмчилгээ	Өдрөөр үзүүлэх эмийн эмчилгээ	120,000
3	10000002 ¹		Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин /J02-J04, J09-J11, J12-J18, J20, J31/	80,000
4	10000002 ²		Хүүхдийн халдвар бус суулгалт өвчин /K52.9/	60,000
5	10000003	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ /цогц тусламж, үйлчилгээ/	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ /Z51.5/	150,000
6	10000004		Эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрсний дараах эх, нярай, хүүхдэд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ	100,000
7	10000005		Бусад гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	50,000
8	10113024	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Туузан оношлуураар (хэмжээ, хувийн жин, PH, уураг, улаан эс, нитрит, сахар, уробилиноген, цагаан эс, кетон)	6,000
9	10113025	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Шээсний тунадаснаас наац бэлтгэж микроскопоор шинжлэх (техниктэй бол)	8,000
10	10113019	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Шээсний ерөнхий шинжилгээ	6,000
11	10110013	Шимэгч судлалын шинжилгээ	Шимэгч хорхойн өндөг илрүүлэх (микроскопоор харах)	5,000
12	10105044	Гематологийн шинжилгээ	Цусны резус бүлэг үзэх	11,000
13	10104005	Гематологийн шинжилгээ	Улаан эсийн тунах хурд тодорхойлох	4,500
14	10104008	Гематологийн шинжилгээ	Цусны ерөнхий шинжилгээ	14,000
15	10102097	Биохимийн шинжилгээ	Цусанд сахар үзэх (өглөөний өлөн цусанд тодорхойлох)	3,000
16	10102098	Биохимийн шинжилгээ	Глюкозын зохих тунг өгсөнөөс хойш 1 ба 2 цагийн дараа цусны сахар тодорхойлох	3,000
17	10102013	Биохимийн шинжилгээ	Билирубин нийт	3,000
18	10102057	Биохимийн шинжилгээ	Нийт уураг	3,000
19	10102003	Биохимийн шинжилгээ	АЛАТ тодорхойлох	3,000
20	10102010	Биохимийн шинжилгээ	АСАТ тодорхойлох	3,000
21	10102035	Биохимийн шинжилгээ	Креатинин (сийвэн болон шээсэнд)	4,000
22	10102006	Биохимийн шинжилгээ	Амилаза	5,000
23	10102086	Биохимийн шинжилгээ	Шүлтлэг фосфатаза (ШФ)	4,000

24	10102018	Биохимийн шинжилгээ	Гаммаглутамилтрансфераз (ГГТ)	3,000
25	10102081	Биохимийн шинжилгээ	Холестрин	3,000
26	10102067	Биохимийн шинжилгээ	С урвалжит уураг	11,000
27	10106243	Түргэвчилсэн оношлуур	HBV хурдавчилсан сорил	6,000
28	10106244	Түргэвчилсэн оношлуур	HCV хурдавчилсан сорил	6,000
29	10106172	Түргэвчилсэн оношлуур	Тэмбүүгийн хурдавчилсан сорил	5,000
30	10106246	Түргэвчилсэн оношлуур	ХДХВ хурдавчилсан сорил	6,000
31	10106247	Түргэвчилсэн оношлуур	Амьсгалын замын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуур	6,000
32	10106248	Түргэвчилсэн оношлуур	Суулгалтат халдварын илрүүлэх	6,000
33	10106249	Түргэвчилсэн оношлуур	Хеликобактер илрүүлэх	6,000
34	10102110	Түргэвчилсэн оношлуур	Сахар илрүүлэх	3,000
35	10102111	Түргэвчилсэн оношлуур	Холестерин илрүүлэх	6,000
36	10106167	Түргэвчилсэн оношлуур	Тропонин (Troponin cassette)	25,000
37	10106251	Түргэвчилсэн оношлуур	Стафилококкийн хурдавчилсан сорил	6,000
38	10106252	Түргэвчилсэн оношлуур	Стрептококийн хурдавчилсан сорил	6,000
39	10105045	Гематологийн шинжилгээ	Цусны бүлэг тодорхойлох	6,000
40	10105046	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо тодорхойлох	15,000
41	10112007	Эд эсийн шинжилгээ	Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах (ПАП сорил)	10,000
42	10112008	Эд эсийн шинжилгээ	Үтрээний арчдасын шинжилгээ	10,000
43	10201005	Багажийн шинжилгээ	Зүрхний цахилгаан бичлэг	9,000
44	10203002	Бүх төрлийн хэт авиан оношилгоо	Хэт авиан оношилгоо	15,000
45	10214006	Рентген оношилгоо	Рентген харалт (Цээж, хэвлий)	10,000
46	10201009	Багажийн шинжилгээ	Ургийн зүрхний цахилгаан бичлэг	30,000
47	10102021	Түргэвчилсэн оношлуур	Сахарын түргэвчилсэн оношлуур	3,000
48	10102004	Биохимийн шинжилгээ	Альбумин	3,000
49	10102001	Биохимийн шинжилгээ	NH3	5,000
50	10105047	Иммуно гематологийн шинжилгээ	Эргэлзээтэй бүлэг тодорхойлох	9,000
51	10102009	Биохимийн шинжилгээ	Антистрепитоллизин О тест (ASLO /ASO) (тоогоор)	10,000
52	10102011	Биохимийн шинжилгээ	Бага нягтралтай липопротеин	10,000
53	10102014	Биохимийн шинжилгээ	Билирубин шууд	3,000
54	10102015	Биохимийн шинжилгээ	Билирубин шууд бус	3,000
55	10102016	Биохимийн шинжилгээ	Бөөрний түүдгэнцэрийн шүүлтийн хурдыг тодорхойлох шинжилгээ	3,000
56	10102094	Биохимийн шинжилгээ	Шээсэнд уураг, креатинины харьцаа үзэх	5,000
57	10102027	Биохимийн шинжилгээ	Их нягтралтай липопротеин	6,000
58	10102028	Биохимийн шинжилгээ	Кали	5,000
59	10106253	Түргэвчилсэн оношлуур	Холестрины түргэвчилсэн оношлуур	3,000

60	10102030	Биохимийн шинжилгээ	Кальци	4,000
61	10102062	Биохимийн шинжилгээ	Нийт уураг (шээс)	6,000
62	10102031	Биохимийн шинжилгээ	Кальци (шээс)	3,000
63	10102043	Биохимийн шинжилгээ	ЛДГ	4,000
64	10102046	Биохимийн шинжилгээ	Липаза	6,000
65	10102047	Биохимийн шинжилгээ	Липопротейн А	8,000
66	10102048	Биохимийн шинжилгээ	Магни	4,000
67	10102052	Биохимийн шинжилгээ	Мочевин	4,000
68	10102036	Биохимийн шинжилгээ	Креатинин клиренс	3,000
69	10102037	Биохимийн шинжилгээ	Креатинфосфокиназа МВ	10,000
70	10102038	Биохимийн шинжилгээ	Креатинфосфокиназа NAC	3,000
71	10102055	Биохимийн шинжилгээ	Натри	5,000
72	10102056	Биохимийн шинжилгээ	Натри (шээс)	5,000
73	10102066	Биохимийн шинжилгээ	Ревматоид фактор /PF/ (тоогоор)	9,000
74	10102070	Биохимийн шинжилгээ	Төмөр	4,000
75	10102071	Биохимийн шинжилгээ	Трансферрин	9,000
76	10102072	Биохимийн шинжилгээ	Триглицерид	3,000
77	10102073	Биохимийн шинжилгээ	Уусдаг трансферрин рецептор (Soluble transferrin receptor)	9,000
78	10102074	Биохимийн шинжилгээ	Үлдэгдэл азот	3,000
79	10102075	Биохимийн шинжилгээ	Фосфор	3,000
80	10102076	Биохимийн шинжилгээ	Фосфор (шээс)	3,000
81	10102077	Биохимийн шинжилгээ	Фруктозамин	2,000
82	10102079	Биохимийн шинжилгээ	Хлор	5,000
83	10102080	Биохимийн шинжилгээ	Хлор (шээс)	6,000
84	10102082	Биохимийн шинжилгээ	Холинэстераза	3,000
85	10102083	Биохимийн шинжилгээ	Хүчиллэг фосфотаза	4,000
86	10102085	Биохимийн шинжилгээ	Цусны осмос тодорхойлох	5,000
87	10102087	Биохимийн шинжилгээ	Шээсний осмос тодорхойлох	5,000
88	10102091	Биохимийн шинжилгээ	Шээсний хүчил (цус)	3,000
89	10102092	Биохимийн шинжилгээ	Шээсний хүчил (шээс)	3,000
90	10102093	Биохимийн шинжилгээ	Шээсэнд глюкоз тодорхойлох	5,000
91	10202004	Бүх төрлийн дурангийн оношилгоо	Хатуу дуран (хамар, чих, арьс, вүүдийн ламп)	30,000
92	10105038	Иммуно гематологийн шинжилгээ	Сөрөг Резус Д баталгаажуулах	7,000
93	10106255	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	6,000
94	10106014	Иммунологийн шинжилгээ	Сүрьеэгийн эсрэг биеийн шинжилгээ (anti TB cassette)	9,000
95	10106112	Иммунологийн шинжилгээ	Глюкозжсон гемоглобин	17,000

96	10102020	Биохимийн шинжилгээ	Глутамат дегидрогеназа-GLDH (Glutamate dehydrogenase)	5,000
97	10102063	Биохимийн шинжилгээ	Нойр булчирхайн амилаза (П амилаза)	6,000
98	10102065	Биохимийн шинжилгээ	Преальбумин	8,000
99	10213002	Нүдний эмгэгийн багажийн оношилгоо	Нүдний эмгэгийн багажийн оношилгоо (Харааны талбайн шинжилгээ, нүдний угийн фото зураг)	30,000
100	10214002	Рентген оношилгоо	Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	10,000
101	10214003	Рентген оношилгоо	Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000
102	10106254	Түргэвчилсэн оношлуур	Жирэмсэн илрүүлэх түргэвчилсэн оношлуур	3,500
103	10108024	Халдварын молекул шинжилгээ	Хүний папилома вирус (HPV) тодорхойлох хурдавчилсан аргын шинжилгээ	15,000
104	10109001	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	АРТТ	5,000
105	10109005	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Fibrinogen	6,000
106	10109012	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	ТТ	5,000
107	10109019	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	РТ (INR)	5,000
108	10110014	Түргэвчилсэн оношлуур	Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /Хурдавчилсан оношлуур/	8,000
109	10102008	Биохимийн шинжилгээ	Амилаза(шээс)	5,000
110	10102029	Биохимийн шинжилгээ	Кали (шээс)	5,000
111	10102049	Биохимийн шинжилгээ	Магни (шээс)	3,000
112	10102050	Биохимийн шинжилгээ	Микроальбумин	15,000
113	10102054	Биохимийн шинжилгээ	Мочевин (шээс)	3,000
114	10102039	Биохимийн шинжилгээ	Лактат	5,000
115	10106138	Иммунологийн шинжилгээ	Нарийн гэдэсний вирусын иммуноглобулин М (Enterovirus IgM) ELISA	10,000
116	10106152	Иммунологийн шинжилгээ	С вирусын эсрэг эсрэг бие (aHCV) ELISA	10,000
117	10106169	Иммунологийн шинжилгээ	Түрүү булчирхайн хавдарын маркер (PSA)	21,000
118	10106175	Иммунологийн шинжилгээ	Тэмбүү өвчнийг баталгаажуулах (Syphilis HISCL-TP ab)	30,000
119	10106176	Иммунологийн шинжилгээ	Тэмбүү өвчнийг баталгаажуулах (Syphilis Serodia TP-PA)	13,000
120	10106177	Иммунологийн шинжилгээ	Тэмбүү өвчний илрүүлэг (Syphilis TP-IgG) ELISA	15,000
121	10106178	Иммунологийн шинжилгээ	Тэмбүү өвчний илрүүлэг (Syphilis VDRL)	7,000
122	10106179	Иммунологийн шинжилгээ	Улаанууд вирусын архаг халдвар (Rubella IgG) ELISA	17,500
123	10106185	Иммунологийн шинжилгээ	Ферритин (Ferritin)	26,000

124	10106186	Иммунологийн шинжилгээ	Фолийн хүчил (Folate)	30,000
125	10106196	Иммунологийн шинжилгээ	ХДХВ/ДОХ илрүүлэг ELISA	25,000
126	10106200	Иммунологийн шинжилгээ	Хепатитын В вирусийн цөмийн эсрэг биеийн М уураг (anti-HBc Ig M) ELISA	10,000
127	10106202	Иммунологийн шинжилгээ	Хепатитын В вирусын гадаргуугын эсрэг биеийн үзүүлэлт (HBsAg) ELISA	10,000
128	10106203	Иммунологийн шинжилгээ	Хепатитын В вирусын гадаргуугын эсрэг биеийн үзүүлэлт (HBsAg) электрохимолуминесценц	15,000
129	10106210	Иммунологийн шинжилгээ	Хурдавчилсан ийлдсийн реаген тест (RPR)	8,000
130	10106212	Иммунологийн шинжилгээ	Церулоплазмин	8,000
131	10106213	Иммунологийн шинжилгээ	Цитомегаловирус (CMV antigenemia)	30,000
132	10106208	Иммунологийн шинжилгээ	Ходоод, гэдэсний хавдрын маркер үзэх	35,000
133	10106098	Иммунологийн шинжилгээ	Бүдүүн гэдэсний CEA	22,000
134	10106209	Иммунологийн шинжилгээ	Хөхний СА 15-3	35,000
135	10106230	Иммунологийн шинжилгээ	Элэгний хавдар AFP	20,000
136	10107018	Молекул биологийн шинжилгээ	Хpert MRSA	30,000
137	10107021	Молекул биологийн шинжилгээ	Үтрээний PCR	35,000
138	10109007	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Heparin	20,000
139	10109020	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Цус бүлэгнэх хугацаа	20,000
140	10109021	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Цус гоожих хугацаа	20,000
141	10113003	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Амбурж (Hamburg test)	6,000
142	10113004	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Баасны ерөнхий шинжилгээ	6,000
143	10113005	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Бенс-Джонсоны сорил	6,000
144	10113006	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Гемосидерины сорил	4,000
145	10113007	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Зимницкийн сорил	6,000
146	10113008	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Нечипоренко	6,000
147	10113009	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Өтгөнд далд цус тодорхойлох	12,000
148	10113010	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Порфирины сорил	4,000
149	10113012	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Тромбоцит тоолох	6,000
150	10106168	Иммунологийн шинжилгээ	Түрүү булчирхайн шүүрлийн шинжилгээ	14,000
151	10113014	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Үтрээний наалдцын шинжилгээ	13,000
152	10113015	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Хоногийн /шээс/ уураг тодорхойлох	6,000
153	10113016	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Хоногийн шээсэнд сахар үзэх	6,000
154	10113027	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Өтгөнд далд цус тодорхойлох (микроскопоор харах)	6,000

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН АРГА

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараах төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.
 - 1.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6.2-т заасан Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад багтсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.
 - 1.2 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаас дор заасан тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ. Үүнд:
 - 1.2.1 Түргэн тусламжийн үйлчилгээ
 - 1.2.2 Яаралтай тусламж, үйлчилгээ
 - 1.2.3 Хэвтүүлэн эмчлэх зарим тусламж, үйлчилгээ
 - 1.2.4 Зарим амбулаторийн тусламж, үйлчилгээ
 - 1.2.4.1 Хүүхдийн шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ
 - 1.2.4.2 Шүдний тусламж, үйлчилгээ
 - 1.2.4.3 Сүрьеэ өвчний хяналт
 - 1.2.4.4 Эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ
 - 1.3 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх дараах тусламж, үйлчилгээ тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн төвийг санхүүжүүлнэ.
 - 1.3.1 Зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ
 - 1.3.2 Оношилгоо, шинжилгээ
 - 1.3.3 Өдрийн эмчилгээ
 - 1.3.4 Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ
2. Гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн тусламж, үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг эдийн засгийн ангиллаар Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухай бүр нэмэлтээр санхүүжүүлнэ.
3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д зааснаас бусад анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-д заасны дагуу иргэн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамаарч авна.

4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон болон тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засвар, байрны түрээсийн зардлууд ороогүй бөгөөд энэхүү зардлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу жил бүрийн төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан холбогдох журмын дагуу орон нутгийн төсвөөс эдийн засгийн ангиллаар санхүүжүүлнэ.
5. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн хэмжээг тухайн жилийн Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсвийн хүрээнд дараах өөрчлөлтийн аль нэг нь бүрдсэн үед зайлшгүй шинэчилнэ.
 - 5.1 Үндэсний статистикийн хорооноос зарласан жилийн эцсийн инфляцын сүүлийн хоёр жилийн түвшингүүдийн нийлбэр нь 10 хувиас дээш гарсан үед;
 - 5.2 Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн үед;
 - 5.3 Ам долларын төгрөгтэй харьцах ханш өмнөх өөрчлөлтөөс хойш 20 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн үед;
 - 5.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн тогтолцооны үнэлгээ болон тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанар, үр дүнд хийсэн судалгаа, үнэлгээгээр эрүүл мэндийн салбарын зардал, үр ашигт нөлөөлөл илэрсэн үед.

**ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС
САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг тооцох

А. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн хэмжээг тооцох аргачлал.

- 2.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг дараах эх үүсвэрийн нийлбэрээр тооцно:

- 2.1.1. нэг иргэнээр тооцсон санхүүжилт;
2.1.2. тохиолдлоор тооцсон эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт;
2.1.3. байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт;
2.1.4. эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилт.
2.1.5. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт

$$НС = НИС + ЭТҮС + ТЗС + ТС + УС$$

Энд,

НС – тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилт

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт

ЭТҮС – эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт

ТЗС – байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт

ТС – тохиолдолд суурилсан тусламж, үйлчилгээний санхүүжилт

УС – гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт

- 2.2. Нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилтийн хэмжээг хүн амын насны бүлэг, амьдарч байгаа орон байрны нөхцөлийн хүчин зүйлийг харгалзан ялгаатай тогтоосон тарифыг тухайн сумын эрүүл мэндийн төвд бүртгүүлсэн оршин суугаа

хүн амын тоо болон тухайн эрүүл мэндийн байгууллагын газарзүйн индексээр тус тус үржүүлж тооцно. Газарзүйн индексийн энэхүү журмын хавсралтад заасны дагуу мөрдөнө.

$$\text{НИС} = \sum_{k=0}^n \binom{n}{k} \text{ХАК} \times \text{ТАР}) * \text{ГЗК} * \text{ОНН}$$

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт

ХАК – хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент

ТАР – нэг иргэнд ногдох зардлын хэмжээ

ГЗК – газар зүйн коэффициент

ОНН – орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициент

2.2.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршлын онцлогоос хамаарсан газарзүйн коэффициентыг дор дурдсан томьёо ашиглан тооцох бөгөөд дараах зүйлсийг харгалзана:

$$\text{ГЗК}_i = (W_{i1} * D_{si} + W_{i2} * R_{si} + W_{i3} * \text{Pop}_{si} + W_{i4} * S_{si}) + A$$

Энд,

ГЗК_i – газар зүйн коэффициент

W_{i1} – сум, тосгоны төвөөс аймгийн төв хүртэлх зайн харгалзах хувийн жин

D_{si} – сум, тосгоны алслалтаас хамаарсан индекс

W_{i2} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусын харгалзах хувийн жин

R_{si} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс

W_{i3} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний хүн амын тооны харгалзах хувийн жин

Pop_{si} – эрүүл мэндийн төвд бүртгэлтэй хүн амаас хамаарсан тэгш байдлын индекс¹

W_{i4} – замын бартааны үзүүлэлтээс харгалзах хувийн жин

S_{si} – замын бартаанаас хамаарсан индекс

A – тэнцвэржүүлэгч коэффициент- 0.5

2.2.2. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршлын онцлогоос хамаарсан газарзүйн коэффициентууд нь дор дурдсан хувийн жингээс бүрдэнэ.

2.2.2.1. W_{i1} – алслалт 20 хувь;

2.2.2.2. W_{i2} – үйлчлэх хүрээний радиус 30 хувь;

2.2.2.3. W_{i3} – хүн амын тэгш байдал 20 хувь;

2.2.2.4. W_{i4} – замын бартаа 30 хувь.

2.2.3. алслалтын хэмжээг сум, тосгоны төвөөс харьяа аймгийн төв хүртэлх зайгаар /км/ тооцно;

¹ Тэгш байдлын индекс нь “Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад” хүрэх Тогтвортой хөгжлийн зорилтын 3.8.2 дахь шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор иргэдийн оршин байгаа газраас үл хамааран чанартай эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авах боломжийг бий болгосон зардлын тохируулагч тооцоолол юм.

2.2.4. үйлчлэх хүрээний радиусыг тухайн эрүүл мэндийн байгууллагаас үйлчлэх хүрээний хамгийн алслагдсан зайн хэмжээгээр /км/ тооцно;

2.2.5. замын бартааг тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийн хэмжээгээр тооцно;

2.2.6. алслалтаас хамаарсан индексийг тухайн сум, тосгоны алслалтыг нийт сум, тосгоны алслалтын дундаж зайнд харьцуулж тооцно. Томьёогоор илэрхийлбэл:

$$Ds_i = \frac{D_i}{D}$$

Энд,

Ds_i – алслалтын индекс

D_i – сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зай /км/

D – нийт сум, тосгоны дундаж алслалт (127 км)

2.2.7. үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индексийг сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусыг нийт сум, тосгоны үйлчлэх хүрээний радиусын дундаж хэмжээнд харьцуулж тооцно. Томьёогоор илэрхийлбэл:

$$Rs_i = \frac{R_i}{R}$$

Энд,

Rs_i – үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс

R_{si} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний зай /км/

R – үйлчлэх хүрээний дундаж радиус (107 км)

2.2.8. хүн амын тооноос хамаарсан тэгш байдлын индексийг нийт сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хамгийн их хүн амтайгаас тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүртгэлтэй хүн амын тоог хасаж нийт сум, тосгоны хүн амын дундаж тоонд харьцуулж квадрат зэрэгт дэвшүүлж тооцно. Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хүн амын тоо 1500-с доош буюу хэт цөөн хүн амтай бол хүн амын тооноос хамаарсан тэгш байдлын индексийг 2 дахин үржүүлж тооцно². Томьёогоор илэрхийлбэл:

$$Pops_i = \left(\frac{Pop_m - Pop_i}{P} \right)^2$$

Энд,

$Pops_i$ – хүн амын тооноос хамаарсан тэгш байдлын индекс

Pop_m – Монгол Улсын хүн ам хамгийн ихтэй сумын хүн амын тоо

Pop_i – тухайн сум, тосгоны бүртгэлтэй хүн амын тоо

P – үйлчлэх хүрээний хүн амын дундаж (3141)

² Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан сумдын хувьд хүн ам нь хэт цөөнөөс болоод санхүүжилтийн хомсдолд орж байгаа нь Монгол Улсын хилийн болон алслагдсан сум, нийгмийн бүлгүүдийн тэгш бус байдлыг үүсгэх эрсдэлтэй учир тэгш байдлыг индексийг 1500-гаас доош хүн амтай бол 2 дахин үржүүлж тооцно.

2.2.9. замын бартаанаас хамаарсан индексийг тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийг нийт сум, тосгоны дундаж өндөрт харьцуулж тооцно. Замын бартаанаас хамаарсан индексэд харгалзах хуваарилалтыг томъёогоор илэрхийлбэл:

$$Ss_i = \frac{S_i}{S}$$

Энд,

Ss_i – хүн амын тооноос хамаарсан индекс

S_i – тухайн сумын далайн түвшнээс дээш өргөгдсөн өндөр /м/

S – далайн түвшнээс өргөгдсөн өндрийн дундаж (1381 м)

2.3. Орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициентийг энэ журмын хавсралтаар баталсан хэмжээгээр анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрээр тооцно.

2.3.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан албан хаагчдын орон тоо, Засгийн газрын шийдвэрээр батлан гаргасан орон нутгийн нэмэгдэл.

2.3.2. Орон нутаг болон алслагдсан дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийн албан хаагчдад Засгийн газрын шийдвэрээр батлан гаргасан орон нутгийн нэмэгдэл тус тус багтана.

2.4. Бүртгэлтэй хүн амын тоонд Үндэсний статистикийн хорооноос гаргасан тухайн нутаг дэвсгэрт албан ёсоор оршин суугаа суурин хүн ам болон тухайн баг, хороонд албан ёсоор түр оршин суух үнэмлэх авсан хүн амыг тооцно.

2.5. Тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр тооцсон тусламж, үйлчилгээг ЭМДҮЗ-өөс баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д заасны дагуу баталсан лавлагаа шатны тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн аргын дагуу энэ тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авна.

2.6. Эрүүл мэндийн төвийн байрлаж байгаа байрны түлш, халаалт, цэвэр болон бохир ус, цахилгаан эрчим хүч, байрны түрээс зэрэг байр ашиглалтын зардлыг тухайн барилга байгууламжийн эзлэхүүн, өмнөх жилийн зардлын суурь түвшнийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж байгаа үнэ тарифын өөрчлөлттэй харьцуулан тооцно. Тус зардлыг орон нутгийн төсвөөс хариуцна. Байр ашиглалттай холбоотой зардал дараах орцоос бүрдэнэ:

2.6.1. түлш, халаалтын зардал;

2.6.2. цахилгаан эрчим хүчний төлбөр;

2.6.3. цэвэр, бохир усны төлбөр;

2.6.4. байрны түрээсийн төлбөр.

2.6.5. урсгал засвар

2.7. Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасны дагуу тогтоосон тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг баримтлах бөгөөд дор дурдсан тусламж үйлчилгээний багцыг хамруулж, санхүүжилтийг энэ журмын дөрөвдүгээр зүйлээр зохицуулна.

2.7.1. зарим сэргээн засах тусламж үйлчилгээ;

2.7.2. гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ;

2.7.3. өдрийн эмчилгээ;

2.7.4. оношилгоо шинжилгээ.

- 2.8. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт нь тухайн тайлант хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан чанарын шалгуур үзүүлэлт, 16 дугаар зүйлийн 16.1.13-д заасан урамшууллыг олгох журмын хүрээнд тухайн жилд ЭМДҮЗ-өөс тухайн зориулалтаар батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.9. Энэ журмын 2.8-д заасан урамшууллыг олгохдоо дараах чанар, үр дүнгийн зорилгод хүрсэн эсэхэд үндэслэж гэрээний дагуу шалгуур хангасан байгууллагад улирал бүр тооцож олгоно.
- 2.9.1. Зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлсэн байдал
- 2.9.2. Бүртгэлтэй хүн амаа тогтмол хянаж, зайлшгүй шаардлагатай тохиолдлоос бусад өвчний улмаас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээж буй иргэдийн тоог бууруулсан байдал
- 2.9.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байдал
- 2.10. Энэ журмын 2.9-д заасан урамшууллыг эрүүл мэндийн байгууллагад олгохдоо тухайн тайлант хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулсан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тусгайлан олгож болно.
- 2.11. Энэ журмын 2.9.1-д заасан шалгуур үзүүлэлт нь сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт болон тухайн суманд хамаарах бүртгэлтэй хүн амын тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангаж буй байдлыг харгалзаж гэрээнд заасны дагуу дүгнэнэ.
- 2.12. Энэ журмын 2.9.2-д бүртгэлтэй хүн амаа Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д зааснаас бусад шалтгаанаар дээд шатлал руу шаардлагагүй илгээсэн, бүртгэлтэй иргэнийг тогтмол хянасан эсэхэд үндэслэж гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.13. Энэ журмын 2.9.3-д заасан урамшууллыг тооцохдоо эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд үндэслэсэн холбогдох байгууллагын албан ёсны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулсан байдал үндэслэж хэрэгжүүлнэ.
- 2.14. Гүйцэтгэлийн урамшууллыг цахим програм хангамжид үндэслэн хараат бус байдлаар дүгнэж, үр дүнг эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ил, тод нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Б. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн хэмжээг тооцох аргачлал.

- 2.15. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт нь улсын төсвөөс хариуцах нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилтийн нийлбэрээр тодорхойлогдох ба дараах томьёогоор илэрхийлэгдэнэ:

$$НС = НИС + ТС + УС$$

Энд,

НС – тухайн өрхийн эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилт

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт
ТС – тохиолдолд суурилсан тусламж, үйлчилгээний санхүүжилт
УС – гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт

- 2.16. Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг энэхүү аргачлалын 2.2 болон 2.3-т заасны дагуу, эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж үйлчилгээний санхүүжилтийг энэхүү аргачлалын 2.7-д заасны дагуу тус тус тооцно.
- 2.17. Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт нь тухайн тайлант хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан чанарын шалгуур үзүүлэлт, 16 дугаар зүйлийн 16.1.13-д заасан урамшууллыг олгох журмын хүрээнд тухайн жилд ЭМДҮЗ-өөс тухайн зориулалтаар батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.18. Энэ журмын 2.17-д заасан урамшууллыг олгохдоо дараах чанар, үр дүнгийн зорилгод хүрсэн эсэхэд үндэслэж гэрээний дагуу шалгуур хангасан байгууллагад улирал бүр тооцож олгоно.
 - 2.18.1. Зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлсэн байдал
 - 2.18.2. Бүртгэлтэй хүн амаа тогтмол хянаж, зайлшгүй шаардлагатай тохиолдлоос бусад өвчний улмаас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээж буй иргэдийн тоог бууруулсан байдал
 - 2.18.3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеэр ажлын бус цагаар болон амралтын өдрүүдэд илүү цагаар иргэдэд хүрч, үр дүн гаргаж ажилласан байдал
 - 2.18.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байдал
 - 2.18.5. Харьяаллын бус хүн амд үзүүлсэн анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэл
- 2.19. Энэ журмын 2.18-д заасан урамшууллыг эрүүл мэндийн байгууллагад олгохдоо тухайн тайлант хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулсан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тусгайлан олгож болно.
- 2.20. Энэ журмын 2.18.1-д заасан шалгуур үзүүлэлт нь Өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт болон тухайн өрхөд хамаарах бүртгэлтэй хүн амын тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангаж буй байдлыг харгалзаж гэрээнд заасны дагуу дүгнэнэ.
- 2.21. Энэ журмын 2.18.2-д бүртгэлтэй хүн амаа Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д зааснаас бусад шалтгаанаар дээд шатлал руу шаардлагагүй илгээсэн, бүртгэлтэй иргэнийг тогтмол хянасан эсэхэд үндэслэж гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.22. Энэ журмын 2.18.3-д заасан урамшууллыг олгохдоо Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Эрүүл мэндийн газраас албан ёсоор томуу, томуу төст өвчний дэгдэлтийг тодорхойлсны үед тооцох бөгөөд үүнд илүү цагаар ажиллахаас гадна, ажиллах хугацаандаа тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдлыг ижил тэнцүү харгалзан холбогдох тооцооллыг хийж хэрэгжүүлнэ.
- 2.23. Энэ журмын 2.18.4-д заасан урамшууллыг тооцохдоо эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд үндэслэсэн

холбогдох байгууллагын албан ёсны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулсан байдал үндэслэж хэрэгжүүлнэ.

- 2.24. Энэ журмын 2.18.5-д заасан урамшууллыг тооцохдоо тухайн өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлгүй хэдий ч анхан шатны тусламж, үйлчилгээг зайлшгүй шаардлагаар авсан тохиолдлын гүйцэтгэлд үндэслэж гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.25. Гүйцэтгэлийн урамшууллыг цахим програм хангамжид үндэслэн хараат бус байдлаар дүгнэж, үр дүнг эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ил, тод нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Гурав. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт тавих

- 3.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь тухайн шатны Засаг даргын тамгын газар, Статистикийн хэлтэстэй хамтран төсвийн тооцоолол хийхэд шаардлагатай сум, баг, хорооны бүртгэлтэй оршин суугаа хүн амын тоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн статистик, мэдээллийг гаргаж жил бүрийн 6 дугаар сарын 15-ээс өмнө эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлнэ.
- 3.2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүртгэлтэй оршин суугаа хүн амын тоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо мэдээллийг Монгол Улсын хүн амын тоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээний статистик мэдээлэлтэй тулгаж, шинээр төрсөн хүүхэд болон нас баралтын зөрүүний сүүлийн 3 жилийн дундаж хүн амын цэвэр өсөлтийн дүнгээр нэмэлтээр тус тус тооцож, энэхүү журмын 2.1, 2.15-д заасан аргачлалын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тухайн жилийн нийт санхүүжилтийг тооцож, Төсвийн тухай хуульд заасан төсөв боловсруулах, өргөн барих цаглабрын дагуу Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 3.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийн төслийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нягтлан нэгтгэж ирүүлсэн холбогдох статистик мэдээлэлтэй тулган хянаж 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 3.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар батлуулж, төсвийн нарийвчилсан хуваарийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталгаажуулан аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.
- 3.4.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт тухайн орон нутгийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хуваарилсан санхүүжилтийн зарлагын сарын хуваарийг хүргүүлнэ.
- 3.4.2. Энэхүү журмын 2.1, 2.15-т заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилтэд багтсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын

санхүүжилтээс бусад тусламж, үйлчилгээний нэр, төрөл бүр дээр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар байгуулна.

3.4.3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв тус бүрийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувьтай тэнцэх дүнг (сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд хүн амын тооноос хамааруулж газар зүйн коэффициентоор үржүүлээгүй дүнгээс тооцно) үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд суурилан санхүүжүүлнэ.

3.4.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээнд тусгасан дүнгээр холбогдох хууль заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийн хуваарийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн хүрээнд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.4.5. Орон нутгийн төсвөөс “гүйцэтгэлд суурилсан санхүүжилт”-д зориулан нэмэлт төсөв хуваарилж болно.

3.4.6. Энэ журмын 2.9, 2.18-д заасан урамшуулал нь гэрээнд заасан чанар, үр дүнгийн шалгуур хангасан байгууллагад нэмэлт урамшуулал хэлбэрээр олгох бөгөөд энэ журмын 3.4.3-д зааснаас ялгаатай байдлаар хэрэгжинэ.

3.5. Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд шилжүүлэхийг хориглоно.

3.6. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсэгт заасан сумын нэгдсэн эмнэлгийг, тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амаар нэг иргэнээр тооцсон санхүүжилт авсан бол нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар давхардуулан санхүүжүүлэхгүй.

3.7. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалтын бус хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

3.8. Өрхийн эрүүл мэндийн төв нь төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, зориулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр гаргаж, дараа сарын 5-ны дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

3.9. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дор дурдсан үе шатын дагуу хянаж, санхүүжилтийг олгоно.

3.9.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийг эрүүл мэндийн даатгалын цахим системд бодит цагийн горимоор илгээнэ.

3.9.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу сар бүрийн эцэст цахим

хэлбэрээр үнэлгээ хийж дараа сарын 20-ны дотор “гүйцэтгэлд суурилсан санхүүжилт”-ийг олгоно

3.9.3. ЭМДҮЗ-өөс баталсан болон бусад холбогдох хяналт, үнэлгээний аргуудыг ашиглаж болно.

3.9.4. Тухайн жилд шинээр төрсөн хүүхэд болон нас барсан хүн амын зөрүүг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүн амын өвчлөл, эндэгдлийн статистик тайлангийн мэдээлэлд суурилж, энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан нэг иргэний дундаж төлбөрийн хэмжээгээр үржүүлэн тооцож дараа оны 1 дүгээр улиралд багтааж өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд холбогдох санхүүжилтийг олгоно.

3.9.5. Энэ журмын 2.9 болон 2.18-д заасан урамшууллыг шалгуур хангасан эрүүл мэндийн байгууллагад улирал бүр тооцох, зарим шалгуур үзүүлэлтийг онцлогоос хамаарч сар бүр хэрэгжүүлж болно.

3.10. Гадаадын иргэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авахаар хандсан бол түүнд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжиж буй тусламж, үйлчилгээг тухайн батлагдсан тарифаар үзүүлэх бөгөөд бусад анхан шатны тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

3.11. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу чанартай, чирэгдэлгүй үзүүлнэ.

3.12. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасныг үндэслэн иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ төлбөр авахыг хориглоно.

3.13. Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, арга хэмжээний зарим санхүүжилтийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэх бөгөөд нэг иргэнээр тооцсон санхүүжилттэй давхардуулахыг хориглоно.

3.14. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ дараах шаардлагыг хангаж ажиллана.

3.14.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь иргэн, даатгуулагчид тусламж, үйлчилгээг үзүүлэх бүртээ тусламж, үйлчилгээ эхэлсэн болон дууссан хугацааг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэж, баталгаажуулах;

3.14.2. Эрүүл мэндийн даатгалын системд холбогдож, мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах;

3.14.3. Даатгуулагчийн онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй буюу шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан үзүүлэхгүй байх;

3.14.4. Ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоо даатгуулагчтай үгсэн хуйвалдах, буруу ташаа мэдээлэл өгөх, тулган шаардахгүй байх;

3.14.5. Холбогдох баримт бичиг, бүртгэл, тайланг үнэн зөв мэдээлэх;

3.14.6. Эмчлэх, сувилах, эм барих эрхийн зөвшөөрөлгүй этгээдийг үйл ажиллагаандаа татан оролцуулахгүй байх;

3.14.7. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллага, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

3.15. Уул уурхай, дэд бүтцийн төслийн ажилтан, жуулчин, дотоодын цэрэг, хилийн цэргийн анги, хилийн боомтын албан хаагч, түүний хамт амьдарч буй гэр бүл болон хилээр нэвтэрч буй жолооч зэрэг харьяаллын бус иргэдэд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх бөгөөд дээрх иргэдийн ажил олгогч, үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж, хувь хүний зүгээс тухайн шатны засаг дарга, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй тохиролцон гэрээ байгуулан нэмэлт санхүүжилт олгож болно.

3.16. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрөөс нэмэлт санхүүжилт болон аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс хуулиар хориглоогүй хандив, тусламж, авч болох ба холбогдох хууль, журамд заасны дагуу тайлагнана.

Дөрөв. Өрх, сум тосгоны эрүүл мэнд төвд зарим сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээг санхүүжүүлэх, хяналт тавих журмын зохицуулалт

Тусламж, үйлчилгээний төрөл	Багцыг тооцох	Тохиолдлын тоог хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдолд хамаарах зардлын бүрэлдэхүүн
1. Зарим сэргээн засах үйлчилгээ	Тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэх ба шаардлагатай тохиолдолд өвчний оношоос хамааруулан нэг даатгуулагчид 5 ба түүнээс дээш хоногоор тусламж, үйлчилгээг үзүүлж болно.	Даатгуулагчид сэргээн засахын багцын тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ. Нэг даатгуулагчдад шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.	Сэргээн засахын багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, дасгал, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	1.1. Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүртээ тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна. 1.2. Багц тусламж, үйлчилгээг цочмог өвчний тусламж, үйлчилгээ авсан иргэдэд үзүүлсэн архаг өвчний дараах сэргээн засах тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ.	
2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	Тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэх ба шаардлагатай тохиолдолд өвчний оношоос хамааруулан нэг даатгуулагчид 10 ба түүнээс дээш хоногоор тусламж, үйлчилгээг үзүүлж болно.	Даатгуулагчид тухайн багцын тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ. Нэг даатгуулагчдад шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, дасгал, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	2.1. Эрүүл мэндийн байгууллагуудад ирж тусламж, үйлчилгээ авах боломжгүй, хэвтрийн болон хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай бусад эмзэг бүлгийн даатгуулагчид цогц тусламж, үйлчилгээг үзүүлнэ. 2.2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлсэнг нэг тохиолдлоор тооцож санхүүжүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээний онцлогоос хамаарч гэрт очиж тусламж, үйлчилгээг үзүүлэх тоо нь байдлаас хамаарч харилцан адилгүй байна.	

		2.3. Төрсний дараах 2 сарын хугацаанд эх, нярайн гэрийн эргэлтийг хамтад нь 1 багц болгож санхүүжүүлэх бөгөөд эх, нярайг 5-аас доошгүй удаа цахимаар (идаатгал аппликешн) болон гэрээр хослуулан хянасан байна. 2.4. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тээвэр, шатахууны зардлыг нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн газарзүйн индексээр зохицуулна.	
3. Өдрийн эмчилгээ	Зөвхөн 0-18 насны хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин, халдварт бус суулгалт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзнэ. Бусад даатгуулагчийн тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзнэ.	1. Даатгуулагчид өдрийн эмийн эмчилгээ үзүүлж байх хугацаанд тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 2. Архаг өвчний үед хийх өдрийн эмчилгээг тухайн даатгуулагчид улиралд нэгээс илүүгүй байх; 3. Нэг даатгуулагчдад шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, ижил төстэй тусламж, үйлчилгээг өөр төрлийн эрүүл мэндийн байгууллагаас авсан, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.	Өдрийн эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна
	Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	3.1 Зөвхөн 0-18 насны хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэн тогтоолын нэгдүгээр хавсралтын хүснэгт 2-ын 3-т зааснаар санхүүжүүлнэ. 3.2 Зөвхөн 0-18 насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэн тогтоолын нэгдүгээр хавсралтын хүснэгт 2-ын 4-т зааснаар санхүүжүүлнэ. 3.3 Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүртээ тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна. 3.4 Өдрийн эмийн эмчилгээний нийт тохиолдлын 40%-иас доошгүй тохиолдолд нь хүүхдийн өдрийн эмчилгээний багцын нэхэмжлэл байна. 3.5 Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлан тухай” А/283 тушаалаар батлагдсан тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан өдрийн эмчилгээний оношийн хүрээнд санхүүжүүлнэ.	
4. Оношилгоо, шинжилгээ	Даатгуулагчдад сард 40,000 төгрөг хүртэлх, жирэмсэн эмэгтэйд улиралд 120,000	1. Нийтийг хамарсан аян хэлбэрээр эсхүл сургууль цэцэрлэгийн зохион байгуулалт урьдчилан сэргийлэх үзлэгийг энэ багцаар санхүүжүүлэхгүй, зөвхөн хүн амынхаа нас хүйс, эрүүл мэндийн	

	төгрөг хүртэлх шинжилгээг нэхэмжлэх боломжтой.	эрсдэлд суурилсан, гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн зорилтот туссан эрт илрүүлэгт хамаарна. 2. Нэг даатгуулагчдад шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. 3. Анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн оношилгоо, шинжилгээг ашиглах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд давтан хийж нэхэмжлэх бөгөөд чанар, төлбөрийн хяналтаар шийдвэрлэнэ.	Бүх төрлийн лабораторийн шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	4.1. Багц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалтын дагуу эмчийн заалтаар эрт илрүүлэх, өвчний учир онош тогтоолгох болон өвчний явцыг хянах зорилгоор үзүүлнэ. 4.2. Даатгуулагчид хийгдсэн оношилгоо, шинжилгээний зардлыг тогтоолын 1 дүгээр хавсралтын Хүснэгт 2-ын 9-аас 154-д заасан холбогдох төлбөрийн хэмжээгээр сард 40,000 эсвэл жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд улиралд 120,000 төгрөгийн хязгаараас хэтрүүлэхгүйгээр нэхэмжилж болно. 4.3. Оношилгоо, шинжилгээгээр өвчлөл илэрсэн эмчлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу оношийн хамааралтай бүлгээр хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байгаа бөгөөд хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний өртөгт оношилгоо, шинжилгээний зардал багтсан байдаг тул хасаж тооцно. 4.4. Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүртээ тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна. 4.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамж, хүртээмжид үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнгээр оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээг үзүүлэх гэрээг байгуулна.	

- 4.1. Даатгуулагч нь дараах эрхтэй байна.
 - 4.1.1. Өрхийн эрүүл мэндийн төв болон өөрт ойр байгаа сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй багц тусламж, үйлчилгээг авах;
 - 4.1.2. Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний болон эрүүл мэндийн даатгалын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авах;
 - 4.1.3. Холбогдох хууль, журам, стандарт зөрчсөн, чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн, эрүүл мэндийн төвийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага болон холбогдох хяналтын байгууллагад гомдол гаргах;
- 4.2. Даатгуулагч нь дараах үүрэгтэй байна.
 - 4.2.1. Эрүүл мэндийн төвөөс багц тусламж, үйлчилгээ авах бүртээ өөрийн хурууны хээг уншигч төхөөрөмжөөр уншуулах, хэрвээ хурууны хээг уншуулах боломжгүй тохиолдолд асран хамгаалагчийн хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулах;
 - 4.2.2. Даатгалын байгууллага, эрүүл мэндийн төв, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан авахгүй байх;
 - 4.2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа иргэний үнэмлэх, бусад аргаар баталгаажуулж, холбогдох байгууллагаар хүндэтгэлтэй үйлчлүүлэх;
- 4.3. Эрүүл мэндийн төв нь дараах эрхтэй байна.
 - 4.3.1. Даатгуулагчдад үзүүлсэн багц тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;
 - 4.3.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүй, харьцаа хандлага, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах;
 - 4.3.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих;
 - 4.3.4. Эрүүл мэндийн төв нь даатгалын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;
- 4.4. Эрүүл мэндийн төв нь дараах үүрэгтэй байна.
 - 4.4.1. Эрүүл мэндийн төв нь бүтэц, үйл ажиллагааны стандарт, өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамжийг баримтлан даатгуулагчид энэхүү журмын 4.1-т заасан багц тусламж үйлчилгээг аюулгүй, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй цогц байдлаар үзүүлэх;
 - 4.4.2. Даатгуулагчид багц тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ даатгуулагчийн холбогдох мэдээлэл болон анхан шатны бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр үнэн зөв, бүрэн хөтлөх, хадгалах, илгээх, НӨАТУС бүхий баримтыг олгох, зайлшгүй шаардлагаар цаасан хэлбэрээр хөтөлж болно;
 - 4.4.3. Эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдож, мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах;
 - 4.4.4. Эрүүл мэндийн төвийн хаяг, байршил, талбайн хэмжээ, хүний нөөц, тоног төхөөрөмж, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, оношилгоо шинжилгээний төлбөрийн хэмжээг үнэн зөв мэдүүлэх, өөрчлөлт орсон тохиолдол бүрд албан бичгээр ажлын 7 хоногийн дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэх;
 - 4.4.5. Даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээллээр хангах;
 - 4.4.6. Даатгуулагчийн онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй буюу шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан үзүүлэхгүй байх;

- 4.4.7. Ашиг, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчтай үгсэн хуйвалдах, буруу, ташаа мэдээлэл өгөх, тулган шаардахгүй байх;
- 4.4.8. Холбогдох баримт бичиг, бүртгэл, тайланг үнэн зөв мэдээлэх, эмчлэх, сувилах зөвшөөрөлгүй этгээдийг үйл ажиллагаандаа татан оролцуулахгүй байх;
- 4.4.9. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллага, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 4.4.10. Холбогдох эрх зүйн баримт бичигт дурдсанаас бусад төр хариуцах тусламж, үйлчилгээг нэхэмжлэхгүй байх;
- 4.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах эрхтэй байна.
- 4.5.1. Эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн баталсан журмын дагуу сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн төвтэй даатгалын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.5.2. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, зардлын төлбөрт цахим болон цаасан хэлбэрээр хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж, заавар өгөх;
- 4.5.3. Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон зардлын хэмжээг судлах, үнэлэх, үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;
- 4.5.4. Эрүүл мэндийн сайдын багцын батлагдсан урсгал төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуураар хангасан тохиолдолд тухайн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нийт зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олговол зохих нийт төлбөрөөс хасаж санхүүжүүлнэ.
- 4.5.5. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих.
- 4.6. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах үүрэгтэй байна.
- 4.6.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн төвийн хооронд мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангаж, цахим системд нэвтрэх эрх олгох, даатгуулагчид цахимаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.6.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлын тайланд дүн шинжилгээ хийх, судалгааны дүнг үндэслэн шаардагдах төсвийн хэмжээг тооцох, даатгалын сангийн зарлагын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;
- 4.6.3. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, даатгалын харилцаанд оролцогч талуудыг мэдээллээр хангах
- 4.6.4. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах.

Тав. Хариуцлага

- 5.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагч холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 5.2. Журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журмын хавсралт

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГАЗАРЗҮЙН КОЭФФИЦИЕНТ ³, ОРОН НУТГИЙН ЦАЛИНГИЙН НЭМЭГДЛИЙН ИНДЕКС

№	Аймаг, нийслэлийн нэр	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэр	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс ($W_{i2} * R_{si}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн алслалтаас хамаарсан индекс ($W_{i1} * D_{si}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн замын бартаанаас хамаарсан индекс ($W_{i4} * S_{si}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амаас хамаарсан тэгш байдлын индекс ($W_{i3} * Pop_{si}$)	Газарзүйн коэффициент ($(W_{i1} * D_{si} + W_{i2} * R_{si} + W_{i3} * Pop_{si} + W_{i4} * S_{si}) + A$)	Орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс (ОНН)
1	Архангай	Батцэнгэл	0.93	0.71	1.03	3.58	1.95	2.30
2	Архангай	Булган	1.1	0.37	1.39	4.9	2.3	2.13
3	Архангай	Жаргалант	1.21	2.27	1.16	2.86	2.24	1.89
4	Архангай	Их тамир	1.1	0.27	1.21	1.7	1.59	2.24
5	Архангай	Өгийнуур	0.7	1	0.97	4.41	2.08	2.35
6	Архангай	Өлзийт	0.52	1.34	0.94	4.03	2.01	2.41
7	Архангай	Өндөр-Улаан	1.6	1.22	1.65	1.55	2.03	1.72
8	Архангай	Төвшрүүлэх	0.45	0.44	1.17	4.68	2.01	2.43
9	Архангай	Хайрхан	0.6	1.75	1.43	3.65	2.19	2.06
10	Архангай	Хангай	1.25	2.3	1.53	4.24	2.64	1.92
11	Архангай	Хашаат	0.8	1.78	0.93	4.29	2.23	2.04
12	Архангай	Хоршоолол	0.5	0.45	1.18	15.64	4.22	2.13
13	Архангай	Хотонт	0.8	0.91	1.06	2.9	1.82	2.44
14	Архангай	Цахир	0.85	3.06	1.52	5.37	2.9	2.10
15	Архангай	Цэнхэр	1.6	0.29	1.53	1.37	1.77	2.02
16	Архангай	Цэцэрлэг	0.88	2.12	1.21	3.53	2.26	2.24
17	Архангай	Чулуут	0.65	1.27	1.47	3.13	2.02	2.39
18	Архангай	Тариат	1.1	1.66	1.26	2.3	2	1.93

³ $ГЗК_i = (W_{i1} * D_{si} + W_{i2} * R_{si} + W_{i3} * Pop_{si} + W_{i4} * S_{si}) + A$

19	Архангай	Эрдэнэмандал	1	1.65	1.26	1.69	1.85	2.12
20	Архангай	Мөнхжин ӨЭМТ					1	1.06
21	Архангай	Мөнгөнчагнуур ӨЭМТ					1	1.06
22	Архангай	Манал ӨЭМТ					1	1.06
23	Баян-Өлгий	Алтай	0.75	1.12	1.55	3	2.01	2.22
24	Баян-Өлгий	Алтанцөгц	0.9	0.43	1.36	4.72	2.21	2.31
25	Баян-Өлгий	Баяннуур	0.6	1.26	0.97	2.35	1.69	2.12
26	Баян-Өлгий	Бугат	1	0.05	1.41	3.42	1.92	2.00
27	Баян-Өлгий	Булган	0.7	2.94	1.41	2.16	2.15	1.94
28	Баян-Өлгий	Буянт	1.64	0.72	1.41	4.84	2.53	2.25
29	Баян-Өлгий	Сагсай	1.7	0.27	1.61	2	1.95	1.84
30	Баян-Өлгий	Толбо	1.5	0.76	1.38	3.01	2.12	2.15
31	Баян-Өлгий	Улаанхус	1.54	0.46	1.28	0.09	1.46	1.96
32	Баян-Өлгий	Хотгор	1.4	1.4	1.24	16.94	4.96	1.91
33	Баян-Өлгий	Цагааннуур	0.6	0.69	1.07	6.57	2.45	2.34
34	Баян-Өлгий	Дэлүүн	0.85	1.58	1.33	0.51	1.57	1.95
35	Баян-Өлгий	Ногооннуур	1	0.92	1.33	1.09	1.6	2.11
36	Баян-Өлгий	Цэнгэл	1.4	0.79	1.33	-	1.48	2.00
37	Баян-Өлгий	Жансая ӨЭМТ					1	1.06
38	Баян-Өлгий	Раушан ӨЭМТ					1	1.06
39	Баян-Өлгий	Мейрим ӨЭМТ					1	1.06
40	Баян-Өлгий	Шипагер ӨЭМТ					1	1.06
41	Баянхонгор	Баацагаан	0.9	1.4	0.95	4.19	2.17	2.75
42	Баянхонгор	Баянбулаг	1	2.66	1.63	6.36	3.09	2.20
43	Баянхонгор	Баянговь	1.5	2.45	1.16	4.5	2.69	1.91
44	Баянхонгор	Баянлиг	2	2.18	0.97	3.46	2.52	2.04
45	Баянхонгор	Баян-Овоо	0.75	0.26	0.97	5.13	2.09	2.42
46	Баянхонгор	Баян-Өндөр	1.8	2.76	1.72	5.09	3.13	2.16
47	Баянхонгор	Бөмбөгөр	0.75	1	1.46	4.1	2.18	2.38
48	Баянхонгор	Бууцагаан	1.1	1.74	1.41	3.68	2.34	2.19
49	Баянхонгор	Галуут	1.03	0.95	1.53	3.13	2.08	2.00

50	Баянхонгор	Гурванбулаг	0.6	2.44	1.75	5.55	2.8	2.09
51	Баянхонгор	Жинст	0.9	1	1.02	5.64	2.4	2.50
52	Баянхонгор	Заг	1.3	1.88	0.95	5.85	2.72	2.12
53	Баянхонгор	Өлзийт	1.2	0.18	0.93	3.47	1.87	2.10
54	Баянхонгор	Хүрээмарал	1.2	2.13	1.5	6.43	3.02	2.27
55	Баянхонгор	Шаргалжуут	2.45	0.6	1.51	14	4.61	1.80
56	Баянхонгор	Шинэжинст	1.8	2.65	1.6	5.26	3.1	1.90
57	Баянхонгор	Эрдэнэцогт	0.75	0.28	1.51	2.86	1.81	2.11
58	Баянхонгор	Баянцагаан	3.6	2.46	1.33	3.84	3.24	1.74
59	Баянхонгор	Богд	2.4	1.4	1.33	4.4	2.78	2.03
60	Баянхонгор	Жаргалант	2.6	1.83	1.33	4.67	2.98	2.17
61	Баянхонгор	Оточ мандал ӨЭМТ					1	1.06
62	Баянхонгор	Наран мандал ӨЭМТ					1	1.06
63	Баянхонгор	Оточ номгон ӨЭМТ					1	1.06
64	Баянхонгор	Энхбүрд ӨЭМТ					1	1.06
65	Булган	Баян-Агт	0.6	1.5	1.11	4.17	2.15	2.23
66	Булган	Баяннуур	0.65	1.8	0.7	6.35	2.53	2.52
67	Булган	Бугат	0.65	0.55	0.84	5.79	2.22	2.93
68	Булган	Бүрэгхангай	1.15	0.85	0.93	4.82	2.26	2.24
69	Булган	Гурванбулаг	0.6	1.5	0.79	4.21	2.06	2.63
70	Булган	Дашинчилэн	0.8	1.53	0.76	4.52	2.18	2.37
71	Булган	Могод	0.6	1.32	1.04	5.05	2.27	2.45
72	Булган	Орхон	0.8	0.22	0.77	3.79	1.77	2.35
73	Булган	Рашаант	0.4	2.25	0.99	4.28	2.22	2.36
74	Булган	Сайхан	0.5	1.01	1.07	3.81	1.93	2.25
75	Булган	Сэлэнгэ	2	1.2	0.55	4.21	2.35	2.04
76	Булган	Тэшиг	1.2	2.45	0.74	3.76	2.32	2.01
77	Булган	Хангал	0.65	1.1	0.75	6.82	2.5	2.62
78	Булган	Хялганат	0.7	1.3	0.75	4.62	2.12	2.41
79	Булган	Хишиг-Өндөр	1.5	1.5	0.84	4.57	2.42	2.66
80	Булган	Хутаг-Өндөр	0.65	0.7	0.84	2.22	1.53	2.39

81	Булган	Цоожэд ӨЭМТ					1	1.06
82	Булган	Эмийн цэцэглэн ӨЭМТ					1	1.06
83	Говь-Алтай	Алтай	1.42	3.6	1.57	5.9	3.3	1.91
84	Говь-Алтай	Баянтоорой	0.9	2.6	1.21	15.34	4.72	2.56
85	Говь-Алтай	Бугат	3.7	2.05	1.55	5.77	3.64	1.88
86	Говь-Алтай	Гуулин	0.4	0.9	1.24	16.4	4.45	2.49
87	Говь-Алтай	Дарви	0.8	2.1	1.17	6.38	2.79	2.45
88	Говь-Алтай	Дэлгэр	0.8	1	1.3	5.38	2.41	2.25
89	Говь-Алтай	Жаргалан	0.96	0.97	1.11	6.3	2.57	2.59
90	Говь-Алтай	Тайшир	0.7	0.45	1.19	6.6	2.48	2.55
91	Говь-Алтай	Тонхил	1.8	2.1	1.59	5.63	3.06	2.14
92	Говь-Алтай	Халиун	0.95	1.1	1.04	5.37	2.39	2.05
93	Говь-Алтай	Хөхморьт	1.1	2.15	1.04	5.5	2.67	1.98
94	Говь-Алтай	Цогт	1.2	2	1.66	5.25	2.81	1.98
95	Говь-Алтай	Цээл	1.3	1.8	1.5	5.63	2.83	2.25
96	Говь-Алтай	Чандмань	1.1	2.26	1.65	5.6	2.9	2.33
97	Говь-Алтай	Шарга	0.8	0.89	0.74	6.05	2.35	2.55
98	Говь-Алтай	Эрдэнэ	1.7	2.53	1.77	5.52	3.15	1.85
99	Говь-Алтай	Баян-Уул	1.8	1.5	1.33	4.52	2.64	2.02
100	Говь-Алтай	Бигэр	1.2	1.08	1.33	5.65	2.61	2.78
101	Говь-Алтай	Төгрөг	2	1.5	1.33	5.89	2.98	2.36
102	Говь-Алтай	Энх Алтай ӨЭМТ					1	1.06
103	Говь-Алтай	Жаргалан Алтай ӨЭМТ					1	1.06
104	Говь-Алтай	Марал Алтай ӨЭМТ					1	1.06
105	Говьсүмбэр	Баянтал	0.54	0.6	0.78	15.05	4.03	2.65
106	Говьсүмбэр	Шивээговь	0.72	0.86	0.81	3.53	1.84	2.68
107	Говьсүмбэр	Энхтусдэм ӨЭМТ					1	1.06
108	Дархан-Уул	Орхон	0.4	1	0.46	4.24	1.81	2.33
109	Дархан-Уул	Хонгор	1.4	0.44	0.52	1.49	1.46	2.17
110	Дархан-Уул	Шарын гол	0.6	1.5	0.66	0.34	1.25	2.74
111	Дархан-Уул	Түвшинхолбоо ӨЭМТ					1	1.06

112	Дархан-Уул	Аминхолбоо ӨЭМТ					1	1.06
113	Дархан-Уул	Гэрэлтэй ӨЭМТ					1	1.06
114	Дархан-Уул	Гос хот ӨЭМТ					1	1.06
115	Дархан-Уул	Мэдс ТОБ ӨЭМТ					1	1.06
116	Дорноговь	Айраг	1.3	1.27	0.76	3.73	2.12	2.35
117	Дорноговь	Алтанширээ	1.3	0.9	0.7	14.16	4.11	2.06
118	Дорноговь	Даланжаргалан	1.84	1.56	0.89	4.55	2.54	1.94
119	Дорноговь	Дэлгэрэх	1.58	1.4	0.77	6.23	2.73	2.37
120	Дорноговь	Иххэт	1.62	1.8	0.87	5.91	2.79	2.33
121	Дорноговь	Мандах	1.92	1.75	0.84	6.73	3.02	2.41
122	Дорноговь	Өргөн	1.5	0.6	0.71	5.74	2.43	2.31
123	Дорноговь	Сайхандулаан	1.86	0.98	0.91	14.09	4.34	1.85
124	Дорноговь	Улаанбадрах	2.1	1.35	0.72	6.83	2.98	2.31
125	Дорноговь	Хатанбулаг	2.56	2.45	0.82	4.63	2.93	2.20
126	Дорноговь	Хөвсгөл	1.7	1.76	0.72	6.7	2.92	2.46
127	Дорноговь	Эрдэнэ	1.3	1.06	0.71	5.52	2.42	2.69
128	Дорноговь	Зүүнбаян	0.9	0.5	0.74	6.03	2.3	3.18
129	Дорноговь	Агатова ӨЭМТ					1	1.06
130	Дорноговь	Мишээлт мана ӨЭМТ					1	1.06
131	Дорноговь	Талст зам ӨЭМТ					1	1.06
132	Дорноговь	Борхойн наран ӨЭМТ					1	1.06
133	Дорнод	Баяндун	0.87	1.8	0.68	4.33	2.19	2.09
134	Дорнод	Баянтүмэн	2.2	0.15	0.55	4.94	2.34	2.40
135	Дорнод	Булган	1.2	0.6	0.56	5.94	2.34	2.46
136	Дорнод	Гурванзагал	0.8	1.3	0.51	6.79	2.51	2.68
137	Дорнод	Матад	2	1.5	0.65	4.28	2.45	1.89
138	Дорнод	Сэргэлэн	0.75	0.7	0.55	5.94	2.22	2.34
139	Дорнод	Хөлөнбуйр	0.8	1.3	0.61	6.17	2.42	2.55
140	Дорнод	Цагаан-Овоо	0.8	1.3	0.62	3.58	1.9	2.20
141	Дорнод	Чойбалсан	1.67	0.6	0.61	4.88	2.28	2.54
142	Дорнод	Чулуунхороот	0.8	2.65	0.44	6.2	2.64	2.72

143	Дорнод	Баян-Уул	0.75	2	0.58	2.46	1.79	2.06
144	Дорнод	Дашбалбар	0.9	1.8	0.58	3.95	2.09	2.33
145	Дорнод	Халхгол	2.1	3.6	0.58	4.15	2.85	1.90
146	Дорнод	Асралт үйлс ӨЭМТ					1	1.06
147	Дорнод	Мянган жаргалан ӨЭМТ					1	1.06
148	Дорнод	Ягаан цээнэ ӨЭМТ					1	1.06
149	Дундговь	Адаацаг	1.5	1.04	1.07	4.81	2.44	2.10
150	Дундговь	Баянжаргалан	0.8	1.58	0.89	14.33	4.19	2.06
151	Дундговь	Гурвансайхан	0.76	0.71	0.84	5.82	2.29	2.37
152	Дундговь	Дэлгэрхангай	1.05	1.35	1.06	5.53	2.51	2.22
153	Дундговь	Дэлгэрцогт	0.9	0.45	0.89	6.6	2.45	2.74
154	Дундговь	Дэрэн	0.7	1.68	0.93	5.8	2.48	2.12
155	Дундговь	Луус	0.7	0.55	1.04	6.19	2.37	2.60
156	Дундговь	Өлзийт	1.83	1	0.9	5.42	2.6	2.22
157	Дундговь	Өндөршил	0.9	1.85	0.85	13.89	4.17	2.03
158	Дундговь	Сайнцагаан	0.95	0.4	1.01	2.48	1	1.70
159	Дундговь	Сайхан-Овоо	0.95	2.1	0.95	5.83	2.66	2.07
160	Дундговь	Хулд	2	0.9	0.97	5.43	2.66	2.12
161	Дундговь	Цагаандэлгэр	0.78	1.5	0.98	15.19	4.37	2.33
162	Дундговь	Говь-Угтаал	0.7	1.2	1.01	6.76	2.6	2.82
163	Дундговь	Эрдэнэдалай	1.2	1.14	0.96	1.45	1.67	2.14
164	Дундговь	Боржигон мандал ӨЭМТ					1	1.06
165	Дундговь	Өлзийт мандал ӨЭМТ					1	1.06
166	Завхан	Алдархаан	1.5	0.32	1.21	4.53	2.28	1.99
167	Завхан	Асгат	0.55	2.56	1.25	15.24	4.6	2.05
168	Завхан	Баянтэс	1.1	2.9	1.03	5.1	2.74	1.94
169	Завхан	Баянхайрхан	0.65	2.55	1.35	6.35	2.88	2.16
170	Завхан	Дөрвөлжин	2.7	1.43	1	5.6	3.02	1.91
171	Завхан	Идэр	0.65	0.75	1.42	5.24	2.32	2.54
172	Завхан	Их-Уул	0.85	2.24	1.2	1.06	1.77	1.94

173	Завхан	Нөмрөг	0.8	1.52	1.33	6.14	2.67	2.23
174	Завхан	Отгон	2.5	1.28	1.55	5.11	2.99	1.94
175	Завхан	Сантмаргац	0.6	2.92	1.13	6.76	2.96	2.03
176	Завхан	Сонгино	0.53	2.32	1.31	6.81	2.88	2.63
177	Завхан	Тэлмэн	1.1	1.22	1.3	4.75	2.41	2.14
178	Завхан	Тэс	0.7	3.37	0.93	4.67	2.6	2.17
179	Завхан	Ургамал	0.9	2.36	0.92	14.29	4.38	1.78
180	Завхан	Цагаанхайрхан	1.3	0.44	1.31	14.17	4.21	1.83
181	Завхан	Цагаанчулуут	1.1	0.97	1.54	14.42	4.37	2.17
182	Завхан	Цэцэн-Уул	0.9	2.47	1.39	6.65	3.01	2.40
183	Завхан	Эрдэнэхайрхан	1.6	1.15	1.36	6.5	2.92	2.06
184	Завхан	Яруу	1.7	0.56	1.51	6	2.78	2.10
185	Завхан	Завханмандал	0.85	1.67	1.27	15.08	4.49	2.40
186	Завхан	Түдэвтэй	0.8	1.96	1.27	6.17	2.75	2.78
187	Завхан	Шилүүстэй	1.3	1.35	1.27	6.36	2.81	2.42
188	Завхан	Биндэргарав ӨЭМТ					1	1.06
189	Завхан	Дөрвөн оноо ӨЭМТ					1	1.06
190	Завхан	Мөнхийн алба ӨЭМТ					1	1.06
191	Орхон	Жаргалант	0.4	0.35	0.76	3.98	1.71	3.13
192	Орхон	Мэндцэцэн ӨЭМТ					1	1.06
193	Орхон	Учралтбаяр ӨЭМТ					1	1.06
194	Орхон	Анхны оч ӨЭМТ					1	1.06
195	Орхон	Энхжихмандирваа ӨЭМТ					1	1.06
196	Орхон	Мөнхсүндэрэл ӨЭМТ					1	1.06
197	Орхон	Үйлсбадрах ӨЭМТ					1	1.06
198	Орхон	Мөнхийн гэгээ ӨЭМТ					1	1.06
199	Орхон	Нийцэл ӨЭМТ					1	1.06
200	Өвөрхангай	Баруунбаян-Улаан	0.56	1.75	0.91	4.88	2.27	2.28
201	Өвөрхангай	Бат-Өлзий	0.29	1.24	1.22	0.47	1.29	2.15
202	Өвөрхангай	Баянгол	0.3	0.8	1.05	3.52	1.77	2.23

203	Өвөрхангай	Баян-Өндөр	0.4	1.22	1.17	3.74	1.96	2.11
204	Өвөрхангай	Богд	0.8	1.97	1.1	1.56	1.78	1.91
205	Өвөрхангай	Бүрд	0.35	1.36	1.08	4.71	2.14	2.34
206	Өвөрхангай	Гучин-Ус	0.45	1.04	1.06	5.74	2.31	2.32
207	Өвөрхангай	Зүүнбаян-Улаан	0.48	0.47	1.34	3.48	1.84	2.11
208	Өвөрхангай	Нарийнтээл	0.45	1.35	1.31	3.77	2.05	2.21
209	Өвөрхангай	Өлзийт	0.32	0.88	1.35	5.45	2.27	2.49
210	Өвөрхангай	Сант	0.27	1	1.1	3.88	1.89	2.20
211	Өвөрхангай	Тарагт	0.57	0.35	1.1	4.29	1.93	2.22
212	Өвөрхангай	Төгрөг	0.8	0.95	1.02	4.95	2.23	2.25
213	Өвөрхангай	Уянга	0.6	0.61	1.44	0	1.23	2.28
214	Өвөрхангай	Хайрхандулаан	0.39	0.72	1.36	3.92	1.95	2.24
215	Өвөрхангай	Хужирт	0.2	0.84	1.2	0.86	1.26	2.33
216	Өвөрхангай	Есөнзүйл	1.21	1	1.15	4.78	2.36	2.43
217	Өвөрхангай	Нарны дөш ӨЭМТ					1	1.06
218	Өвөрхангай	Түшигдөлгөөн ӨЭМТ					1	1.06
219	Өвөрхангай	Уян сэтгэл ӨЭМТ					1	1.06
220	Өвөрхангай	Энэрэл Хархорин ӨЭМТ					1	1.06
221	Өмнөговь	Баяндалай	1.8	1.27	1.12	5.9	2.81	2.29
222	Өмнөговь	Баян-Овоо	1	0.9	0.86	6.29	2.5	2.93
223	Өмнөговь	Булган	2.4	1.56	0.59	5.93	2.89	2.26
224	Өмнөговь	Мандал-Овоо	0.9	1.8	0.78	6.65	2.69	2.57
225	Өмнөговь	Манлай	1.8	1.75	0.94	5.03	2.68	2.11
226	Өмнөговь	Номгон	1.98	0.6	1.08	5.21	2.58	2.34
227	Өмнөговь	Сэврэй	1.28	0.98	1.23	5.99	2.65	2.40
228	Өмнөговь	Гурвантэс	3.1	1.4	1.25	2.07	2.5	1.78
229	Өмнөговь	Ханхонгор	1.15	1.35	0.91	6.07	2.6	2.52
230	Өмнөговь	Хүрмэн	2.04	2.45	1.32	6.74	3.35	2.44
231	Өмнөговь	Цогт-овоо	1.3	1.76	1.07	6.22	2.81	2.35
232	Өмнөговь	Ноён	2.71	2.16	1.01	14.09	4.87	2.32

233	Өмнөговь	Ханбогд	1.76	2.5	1.01	0.18	1.87	2.15
234	Өмнөговь	Цогтцэций	1.39	1	1.01	0.17	1.45	2.52
235	Өмнөговь	Шим билэг ӨЭМТ					1	1.06
236	Өмнөговь	Энхийн хүслэн ӨЭМТ					1	1.06
237	Өмнөговь	Өнө орших ӨЭМТ					1	1.06
238	Сүхбаатар	Асгат	1.1	0.48	0.75	6.12	2.38	2.83
239	Сүхбаатар	Баяндэлгэр	0.9	1.45	0.79	2.17	1.73	2.05
240	Сүхбаатар	Дарьганга	1.1	1.7	0.9	4.39	2.32	2.14
241	Сүхбаатар	Мөнххаан	1.1	1.08	0.89	2.34	1.78	2.04
242	Сүхбаатар	Наран	0.6	2.12	0.89	6.57	2.68	2.44
243	Сүхбаатар	Сүхбаатар	1.2	0.8	0.65	3.92	2	2.30
244	Сүхбаатар	Түвшинширээ	1.7	1.4	0.8	4.02	2.33	2.06
245	Сүхбаатар	Түмэнцогт	0.67	1.4	0.71	5.29	2.25	2.47
246	Сүхбаатар	Уулбаян	1.1	0.55	0.75	4.61	2.09	2.40
247	Сүхбаатар	Халзан	0.46	0.68	0.75	6.31	2.26	2.94
248	Сүхбаатар	Эрдэнэцагаан	2.6	2.2	0.78	0.81	2.12	1.69
249	Сүхбаатар	Онгон	1.5	1.65	0.79	3.47	2.21	2.26
250	Сүхбаатар	Энэрэл ачтан ӨЭМТ					1	1.06
251	Сүхбаатар	Энхлэн ачлан ӨЭМТ					1	1.06
252	Сэлэнгэ	Алтанбулаг	1.2	0.25	0.67	2.47	1.61	2.24
253	Сэлэнгэ	Баруунбүрэн	0.75	2.2	0.66	4.4	2.24	2.05
254	Сэлэнгэ	Баянгол	0.55	1.65	0.58	1.69	1.51	2.22
255	Сэлэнгэ	Бугант	0.7	1.3	0.59	4.38	2.02	2.22
256	Сэлэнгэ	Дулаанхаан	0.38	0.46	0.45	6.38	2.12	2.85
257	Сэлэнгэ	Ерөө	0.75	0.92	0.49	3.58	1.77	2.17
258	Сэлэнгэ	Жавхлант	0.5	0.72	0.68	6.05	2.21	2.98
259	Сэлэнгэ	Зүүнбүрэн	0.65	0.5	0.45	4.77	1.88	2.34
260	Сэлэнгэ	Номгон	0.9	1.6	0.59	5.96	2.46	2.33
261	Сэлэнгэ	Орхон	0.75	1.8	0.54	5.59	2.37	2.05
262	Сэлэнгэ	Орхонтуул	1.25	2.2	0.6	6.12	2.72	2.29
263	Сэлэнгэ	Рашаант	0.38	2	0.63	6.3	2.46	2.69

264	Сэлэнгэ	Сант	0.55	2.2	0.62	5.8	2.45	2.33
265	Сэлэнгэ	Түнхэл	0.25	2.65	0.64	3.63	2.02	2.15
266	Сэлэнгэ	Түшиг	1.1	1.3	0.54	6.22	2.5	2.31
267	Сэлэнгэ	Хушаат	0.85	1.1	0.48	5.89	2.3	2.29
268	Сэлэнгэ	Хүдэр	0.45	1.6	0.51	4.94	2.1	2.39
269	Сэлэнгэ	Хэрх	0.47	2.1	0.64	3.99	2.05	2.49
270	Сэлэнгэ	Цагааннуур	0.98	1	0.57	2.12	1.59	1.97
271	Сэлэнгэ	Шаамар	0.4	0.21	0.45	5.62	1.92	2.52
272	Сэлэнгэ	Сайхан	0.7	1.6	0.57	0.63	1.33	2.95
273	Сэлэнгэ	Эмнэх БЭМТ					1	1.06
274	Сэлэнгэ	Номт хан ӨЭМТ					1	1.06
275	Сэлэнгэ	Ачит амьдруулагч ӨЭМТ					1	1.06
276	Сэлэнгэ	Хараа манал					1	1.06
277	Сэлэнгэ	Үйлст эмнэхүй					1	1.06
278	Төв	Алтанбулаг	1.2	0.51	0.88	4.19	2.06	2.17
279	Төв	Аргалант	1.1	1.31	0.89	6.76	2.71	2.52
280	Төв	Архуст	0.3	1.13	0.84	14.2	3.91	2.09
281	Төв	Батсүмбэр	0.7	1.35	0.83	0.8	1.39	2.14
282	Төв	Баян	1.15	0.78	1.03	5.65	2.44	2.25
283	Төв	Баяндэлгэр	0.9	1.06	0.9	6.7	2.59	2.57
284	Төв	Баянжаргалан	1.1	1.41	0.99	6.63	2.73	2.25
285	Төв	Баян-Өнжүүл	0.93	1.31	0.88	5.7	2.44	2.15
286	Төв	Баянхангай	1.6	1.53	0.89	14.1	4.37	1.82
287	Төв	Баянцагаан	1.4	1.12	0.98	6.22	2.68	2.23
288	Төв	Баянцогт	1.2	1.38	0.9	6.49	2.7	2.42
289	Төв	Баянчандмань	0.44	1.11	0.9	3.04	1.73	2.20
290	Төв	Борнуур	1.2	1.44	0.74	2.31	1.83	1.79
291	Төв	Бүрэн	0.64	1.92	0.92	4.65	2.28	1.98
292	Төв	Дэлгэрхаан	1	2.46	1.12	6.4	2.91	2.39
293	Төв	Жаргалант	1.78	1.71	0.73	0.94	1.78	1.99

294	Төв	Заамар	1.4	2.26	0.84	1.55	1.93	1.93
295	Төв	Лүн	1.2	1.75	0.73	5.26	2.48	2.03
296	Төв	Мөнгөнморьт	1	1.94	1.03	5.75	2.65	2.15
297	Төв	Өндөрширээт	1.4	2.31	0.75	6.02	2.81	2.37
298	Төв	Сүмбэр	0.8	2.06	0.76	6.47	2.67	2.51
299	Төв	Сэргэлэн	2.36	0.14	0.83	6.02	2.69	2.32
300	Төв	Угтаалцайдам	1.06	1.99	0.84	5.13	2.49	1.98
301	Төв	Цээл	0.9	2.22	0.76	5.13	2.47	2.08
302	Төв	Эрдэнэ	2	0.83	1.13	3.4	2.29	1.90
303	Төв	Эрдэнэсант	1.6	2.61	0.98	2.75	2.35	1.75
304	Төв	Баруун Зуунмод ББН ӨЭМТ					1	1.06
305	Увс	Бөхмөрөн	0.9	1.8	0.89	5.59	2.52	2.51
306	Увс	Давст	0.85	1.47	0.62	6.69	2.57	2.53
307	Увс	Завхан	1.7	1.8	0.76	6.24	2.85	2.68
308	Увс	Зүүнговь	1.04	1.4	0.72	4.79	2.27	2.33
309	Увс	Зүүнхангай	1.25	3.5	1.3	5.45	3.05	1.90
310	Увс	Малчин	0.9	1.05	1.06	5.35	2.37	2.19
311	Увс	Наранбулаг	1.5	0.9	0.82	2.92	1.96	2.00
312	Увс	Өлгий	1.8	1.11	1.13	5.35	2.67	2.05
313	Увс	Сагил	1.45	0.67	0.82	5.31	2.38	2.35
314	Увс	Тариалан	1.53	0.34	0.67	3.3	1.89	2.02
315	Увс	Түргэн	1.5	0.37	0.88	5.92	2.47	2.43
316	Увс	Тэс	1.2	1.8	0.58	2.09	1.81	2.25
317	Увс	Ховд	2.2	1.86	0.86	5.24	2.84	1.91
318	Увс	Хяргас	1	1.65	0.99	5.2	2.47	2.17
319	Увс	Цагаанхайрхан	1.8	2.4	1.26	5.93	3.08	2.18
320	Увс	Баруунтуруун	0.95	1.88	0.89	4.9	2.41	2.24
321	Увс	Өмнөговь	1.15	1.8	0.89	2.54	1.98	2.15
322	Увс	Өндөрхангай	1.4	2.7	0.89	4.28	2.58	2.06
323	Увс	Бат үржихүй ӨЭМТ					1	1.06

324	Увс	Дун цагаан ӨЭМТ					1	1.06
325	Увс	Элбэг өгөөж ӨЭМТ					1	1.06
326	Увс	Мөнхбишрэлт ӨЭМТ					1	1.06
327	Ховд	Алтай	2.4	3	0.95	4.1	2.92	1.78
328	Ховд	Буянт	1.5	0.25	0.86	3.66	1.99	2.30
329	Ховд	Дарви	1.6	2.2	1.06	4.59	2.66	2.17
330	Ховд	Дөргөн	2	1	0.85	4.46	2.45	1.96
331	Ховд	Дуут	0.75	0.8	1.65	6.1	2.6	2.43
332	Ховд	Зэрэг	4.1	1.41	0.83	4.1	3.08	1.91
333	Ховд	Манхан	1.2	0.8	0.98	2.95	1.9	2.14
334	Ховд	Мөнххайрхан	1.15	1.56	1.51	5.73	2.76	2.12
335	Ховд	Мянгад	1.8	0.45	0.85	3.68	2.12	2.21
336	Ховд	Үенч	1.5	3.65	0.98	3.38	2.65	1.96
337	Ховд	Ховд	0.7	0.33	1.23	3.94	1.93	2.23
338	Ховд	Цэцэг	3	2.32	1.15	4.35	3.08	1.63
339	Ховд	Чандмань	1.6	1.6	1.2	4.48	2.56	1.97
340	Ховд	Эрдэнэбүрэн	1.88	0.62	0.92	5.37	2.54	2.13
341	Ховд	Мөст	1.68	1.85	1.07	4.36	2.57	2.02
342	Ховд	Баатархайрхан ӨЭМТ					1	1.06
343	Ховд	Буянт ӨЭМТ					1	1.06
344	Ховд	Бугат ӨЭМТ					1	1.06
345	Ховд	Рашаант ӨЭМТ					1	1.06
346	Ховд	Жаргалан ӨЭМТ					1	1.06
347	Ховд	Булган ӨЭМТ					1	1.06
348	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	1.1	0.63	1.13	4.15	2.12	2.26
349	Хөвсгөл	Арбулаг	1	0.71	1.36	3.18	1.99	2.02
350	Хөвсгөл	Баянзүрх	1.2	1.27	1.17	3.29	2.12	2.09
351	Хөвсгөл	Бүрэнтогтох	1.02	0.51	0.97	2.82	1.76	2.10
352	Хөвсгөл	Галт	0.96	1.67	1.29	1.83	1.87	2.23
353	Хөвсгөл	Жаргалант	1.05	1.77	1.28	1.81	1.92	1.79

354	Хөвсгөл	Рашаант	0.94	1.54	1	3.53	2.1	2.08
355	Хөвсгөл	Ренчинлхүмбэ	2.1	2.43	1.14	2.38	2.43	1.84
356	Хөвсгөл	Тариалан	1.75	1.6	1.09	1.23	1.92	1.88
357	Хөвсгөл	Тосонцэнгэл	1	0.64	0.93	2.81	1.77	2.20
358	Хөвсгөл	Төмөрбулаг	1.45	0.73	1.05	2.9	1.98	2.19
359	Хөвсгөл	Түнэл	1.4	0.46	1.1	2.93	1.93	2.02
360	Хөвсгөл	Ханх	1.55	3.41	1.19	4.82	2.97	1.91
361	Хөвсгөл	Цагаан-Үүр	1.07	1.73	1.18	5.02	2.52	2.24
362	Хөвсгөл	Цагааннуур	1.15	2.52	1.12	6	2.89	2.35
363	Хөвсгөл	Цэцэрлэг	1.25	2.09	1.26	2.58	2.19	1.90
364	Хөвсгөл	Чандмань-Өндөр	0.98	1.37	1.38	4.43	2.37	2.15
365	Хөвсгөл	Эрдэнэбулган	1.24	1.6	0.83	4.47	2.33	2.03
366	Хөвсгөл	Их-Уул	0.98	1.12	1.14	3.1	1.98	2.30
367	Хөвсгөл	Улаан-Уул	1.15	1.74	1.14	3	2.13	2.07
368	Хөвсгөл	Хатгал	1.1	1.01	1.14	3.76	2.13	2.27
369	Хөвсгөл	Цагаан-Уул	1.25	1.31	1.14	1.53	1.78	2.01
370	Хөвсгөл	Шинэ-Идэр	1.12	1.23	1.14	4.37	2.3	2.26
371	Хөвсгөл	Гурван гал ӨЭМТ					1	1.06
372	Хөвсгөл	Энэрэл ӨЭМТ					1	1.06
373	Хөвсгөл	Далайн элбэрэлт ӨЭМТ					1	1.06
374	Хөвсгөл	Энх-Үйлс ӨЭМТ					1	1.06
375	Хөвсгөл	Дэлгэрмөрөн ӨЭМТ					1	1.06
376	Хэнтий	Батноров	0.45	1.05	0.76	4.17	1.91	2.21
377	Хэнтий	Батширээт	0.55	1.96	0.81	5.44	2.39	2.37
378	Хэнтий	Баян-Адарга	0.75	1.56	0.74	5.31	2.32	2.23
379	Хэнтий	Баянмөнх	0.52	1	0.8	6.41	2.38	2.53
380	Хэнтий	Баян-Овоо	0.55	1.43	0.67	6.15	2.38	2.28
381	Хэнтий	Баянхутаг	0.6	0.27	0.75	5.33	2.03	2.64
382	Хэнтий	Галшар	0.65	1.4	0.85	5.7	2.37	2.12
383	Хэнтий	Гурванбаян	0.35	1.2	0.87	15.68	4.24	1.97
384	Хэнтий	Дадал	0.8	2.8	0.72	4.32	2.38	2.11

385	Хэнтий	Дархан	0.65	1.45	0.92	6.02	2.47	2.04
386	Хэнтий	Дэлгэрхаан	0.6	1.38	0.9	6.08	2.44	2.51
387	Хэнтий	Жаргалтхаан	0.55	1	0.97	5.57	2.27	2.30
388	Хэнтий	Мөрөн	0.55	0.3	0.95	6.24	2.26	2.69
389	Хэнтий	Норовлин	0.8	2.06	0.74	4.95	2.36	2.14
390	Хэнтий	Өлзийт	0.35	0.51	0.95	15.24	4.04	2.01
391	Хэнтий	Өмнөдэлгэр	0.85	1.4	0.96	2.29	1.78	1.93
392	Хэнтий	Тахилгат	0.45	0.5	0.82	16.24	4.23	1.97
393	Хэнтий	Хэрлэн Баян-Улаан	0.45	1.61	0.86	17.14	4.64	2.41
394	Хэнтий	Цэнхэрмандал	0.55	1.45	1.03	5.93	2.45	2.23
395	Хэнтий	Биндэр	0.75	1.8	0.85	3.24	1.99	2.24
396	Хэнтий	Бэрх	0.45	0.75	0.85	5.44	2.13	2.96
397	Хэнтий	Оюуны шим ӨЭМТ					1	1.06
398	Хэнтий	Хэрлэн дом ӨЭМТ					1	1.06
399	Хэнтий	Ач манал ӨЭМТ					1	1.06
400	Хэнтий	Цэгцүүлэн дом ӨЭМТ					1	1.06
401	Улаанбаатар	Гачуурт тосгон	0.95	0.17	1.02	0.56	1.24	2.07
402	Улаанбаатар	Жаргалант тосгон	0.62	0.67	0.84	0.7	1.21	2.09
403	Улаанбаатар	Туул тосгон	0.64	0.37	0.86	3.56	1.74	2.27
404	Улаанбаатар	Хонхор тосгон	0.5	0.22	0.95	0.12	1	2.22
405	Улаанбаатар	Багахангай ДЭМТ	1.15	0.78	1.03	5.65	2.44	2.42
406	Улаанбаатар	Багануур Энэрэлт Өлзий ӨЭМТ					1	1.06
407	Улаанбаатар	Багануур Энх-Өрх ӨЭМТ					1	1.06
408	Улаанбаатар	Багануур Биваангирьд ӨЭМТ					1	1.06
409	Улаанбаатар	Налайх Нарны эрч ӨЭМТ					1	1.06
410	Улаанбаатар	Налайх Амь Эрдэнэ МТ					1	1.06
411	Улаанбаатар	Налайх Ачлал ӨЭМТ					1	1.06
412	Улаанбаатар	Налайх Суврага ӨЭМТ					1	1.06